

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/263
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАН-ЭРДЭНЭ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны спортын яамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2019\0225SAG37.Docx

070606

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлого, зардал, хууль эрх зүйг сайжруулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 28-наас 2 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.

БСШУЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь бүх шатны боловсролын стандартчлагдсан чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, энэ чиглэлээр хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө боловсруулж, бүх шатны боловсролын үйлчилгээнд үнэлгээ хийхэд мэргэжил, арга зүйн зөвөлгөө, дэмжлэг үзүүлэн үндэсний мэдээллийн нэгдсэн сан байгуулж иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

БСШУСС-ын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/61 тушаалаар бүтэц, дүрмийг баталж БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын хэмжээнд бүх шатны боловсролын үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, боловсролын чанарын болон суралцагчдын мэдлэгийн түвшинд үнэлгээ хийх ажлыг төлөвлөн зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, оролцогч талууд болон иргэд үйлчлүүлэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх;

- Бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийж, боловсролын салбарын шинэчлэлд хөгжлийн бодлогыг боловсруулах, сургалт зохион байгуулах замаар хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх, бэхжүүлэх;
- ЕБС-ийн бага, дунд, ахлах анги төгсөгчдийн улсын шалгалт болон их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д элсэгчдийн суралцах чадвар, мэдлэгийн төвшинг тогтооход чиглэсэн улсын хэмжээний элсэлтийн нэгдсэн шалгалтыг зохион байгуулах;
- Боловсролын чанарын үнэлгээний болон суралцагчийн сурлагын амжилт, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнгийн мэдээлэл бүхий мэдээллийн сан бүрдүүлж оролцогч талууд болон иргэдэд үйлчилгээ үзүүлэх зэрэг болно.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлж мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт болон цэвэр хөрөнгө харьцангуй тогтмол үзүүлэлт, орлогын 55.6 хувийг улсын төсвийн санхүүжилт байгааг харгалзан, нийт үйл ажиллагааны зардын дүнгээс тооцох нь илүү бодитой, ажил гүйлгээний төрлийн эрсдэл, төлөвлөснөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан үзсэн.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны үйл ажиллагааны зардал 2,323,191.1 мянган төгрөгийн 2 хувиар буюу 46,463.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг гүйцэтгэлийн үе шатанд шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл дунд гэж үзсэн тул 2 хувь хэмжээг дахин өөрчлөх шаардлага үүсээгүй болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	204,852.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	4	204,852.9	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 2 арга хэмжээнд зориулан 2018 онд 1,988,408.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,913,985.5 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 172,317.4 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 20,717.4 мянган, нийт 193,034.8 мянган төгрөгөөр хэтэрч, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 255,077.8 мянган, томилолт, зочны зардал 10,015.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 1,597.3 мянган, хангамж, бараа материалын зардал 392.7 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 374.6 мянган, нийт 267,457.4 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого /элсэлтийн шалгалтын орлого/ 848,709.5 мянган төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 3,762.0 мянган төгрөгөөр давуулжээ. Туслах үйл ажиллагааны орлого /олон улсын хөтөлбөрт сургуульд элсэгчдийн элсэлтийн шалгалтын хураамж/ 23,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, тус төвд элсэлт зохион байгуулагдаагүйн улмаас төлөвлөгөө тасарсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

БСШУЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Боловсролын үнэлгээний төв нь Шилэн дансны хуульд заасан дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.eec.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 5 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний тушаал, шийдвэрүүдийг оруулсан байна. Тендерээр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, үнийн дүн, тендерт шалгарсан болон шалгараагүй байгууллагуудын нэр, байршил, холбогдох тушаал шийдвэрийн мэдээлэл болон худалдан авах ажиллагааны тайланг оруулсан байна. Жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна. Тайлант хугацаанд нийт 133 мэдээлэл оруулахаас 106 мэдээллийг хугацаанд нь оруулж баталгаажуулан 27 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгөгдсөний 2 зөвлөмж бүрэн биелж, 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгээгүй, авлагыг төлүүлэх график гаргасан, элсэлтийн шалгалтын хураамжийн орлогын бүртгэлийн залруулж чадаагүй зэрэг дутагдалтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Боловсролын үнэлгээний төвийн 14 гэрээт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 171,358.2 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 20,717.4 мянган, нийт 192,075.6 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ зардлаар тайлагнасан нь төлөвлөснөөс 56.3-56.5 хувиар буюу орон тоо 12 ажилтнаар хэтэрсэн байна.

Энэ нь БСШУС-ын 2012 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн А/120, БСШУСС-ын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/61 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар Боловсролын үнэлгээний төвийн орон тоог 38-аар тус тус баталсныг төлөвлөх, тайлагнахдаа мөрдөж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Цалингийн зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

БСШУС-ын 2012 оны А/120, БСШУСС-ын 2017 оны А/61 дүгээр тушаалаар Боловсролын үнэлгээний төвийн орон тоог 38-аар тус тус баталсныг хэрэгжүүлж цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг зөв төлөвлөж, тайлагнах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.2 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Арилжааны банкны харилцах дансаар 855,670.1 мянган төгрөгийн элсэлтийн шалгалтын хураамжийн орлого орсноос банкны шимтгэлийн хураамжийг хасч, 848,559,5 мянган төгрөг Төрийн сангийн харилцахад орсныг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлин тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.3.2-т "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББҮУС-ын холбогдох заалт зөрчигдөх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, орлогыг аккруэл сууриар бүртгэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.3 Дотоод аудит

3.3.1 Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сангаас 2018 онд Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-д нэр заагдаагүй бараа материал, цай кофе, бичиг хэрэг, цэвэрлэгээний материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, шуудан, холбоо, үйл ажиллагааны зардалд нийт 10,400.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Бэлэн мөнгөөр гүйцэтгэх бараа, ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг 18 гүйлгээгээр 5.666,7 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна. Төсөв захирагчийн гарын үсэг 2 янзаар зурагдсан кассын баримт дээр цохолт хийгдээгүй зөвхөн гарын үсгийн дардас дарагдсан байна

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-ын 2.2, 6.3-т заасныг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Бэлэн мөнгөний хадгалалт, хамгаалалт алдагдах, ашиглан залиланд өртөх, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү их бэлэн мөнгөнийг удаан хугацаагаар хадгалах

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-ыг мөрдөж ажиллах, харилцах данснаас шилжүүлэх боломжтой ажил үйлчилгээг цэгцлэх, жижиг мөнгөн сангаас зарцуулах ажил үйлчилгээг журамлаж, хэмжээг багасгах, Төсөв захирагчийн гарын үсгийг баталгаажуулан нэг болгох.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.4 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.4.1 Илрүүлэлт:

Тус төвийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тэмдэг дээрх хуулийн этгээдийн нэр зөрүүтэй байна. Үүнд: Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хуулийн этгээдийн нэр /113874 дугаартай/ - "Боловсролын үнэлгээний төв", тэмдэг дээрх хуулийн этгээдийн нэр - "БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв" "ТБАГУТҮГ", Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хариуцлагын хэлбэр - "Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэж бичсэн нь хариуцлагын хэлбэр тодорхойгүй байна

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын холбогдох заалтыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Хариуцлагын хэлбэр нь хоёрдмол утгатай байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээний болон тэмдэг дээрх хуулийн этгээдийн нэрийг нэг ижил болгох, хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг "Төрийн байгууллага, албан газар" гэж өөрчлүүлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>81,715,650.00</u>	<u>73,430,091.66</u>
33	АВЛАГА	5,777,685.00	5,627,685.00
335	Бусад авлага	5,777,685.00	5,627,685.00
3351	Байгууллагаас авах авлага	5,777,685.00	5,627,685.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,937,965.00	67,802,406.66
351	Түүхий эд материал	44,858,560.00	17,381,800.00
35110	Тусгай зориулалттай материал	44,858,560.00	17,381,800.00
354	Хангамжийн материал	31,079,405.00	50,420,606.66
35410	Бичиг хэргийн материал	12,457,105.00	13,904,106.66
35420	Аж ахуйн материал	680,000.00	15,305,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,133,600.00
35470	Бусад хангамжийн материал	17,942,300.00	20,077,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>960,030,257.79</u>	<u>904,980,760.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	960,030,257.79	904,980,760.14
392	Биет хөрөнгө	832,354,380.67	810,659,856.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,629,400.00	65,629,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,211,201.94	-65,629,400.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,174,924,250.00	1,344,756,946.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-442,272,722.90	-619,956,595.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,739,450.33	93,438,560.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73,454,794.82	-7,579,054.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,534,840.00	1,534,840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,534,840.00	-1,534,840.00
393	Биет бус хөрөнгө	127,675,877.12	94,320,903.81
39301	Програм хангамж	261,924,560.00	296,324,560.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-134,248,682.88	-202,003,656.19
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,041,745,907.79</u>	<u>978,410,851.80</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	308,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	308,000.00
413	Өглөг	00.00	308,000.00
4136	Бусад өглөг	00.00	308,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	308,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,041,745,907.79</u>	<u>978,102,851.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,041,745,907.79	978,102,851.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344,839,013.00	344,839,013.00
51101	Өмч: - төрийн	344,839,013.00	344,839,013.00
512	Хуримтлагдсан үр дүн	696,748,710.36	633,105,654.37
51210	Өмнөх үеийн үр дүн	696,748,710.36	770,551,386.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-137,445,732.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	158,184.43	158,184.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,041,745,907.79</u>	<u>978,410,851.80</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,136,537,519.16	2,377,115,563.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	850,711,319.16	1,130,910,193.87
120	Нийтлэг татварын бус орлого	850,711,319.16	1,130,910,193.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	850,711,319.16	1,114,867,193.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,711,319.16	848,559,497.87
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	266,307,696.00
120009	Бусад орлого	00.00	16,043,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,285,826,200.00	1,246,205,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,125,976,700.00	1,130,113,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,125,976,700.00	1,130,113,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,849,500.00	116,092,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	116,092,270.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,031,152,457.43	2,323,191,080.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,031,152,457.43	2,323,191,080.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,013,405,886.41	2,241,999,903.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,870,705.00	553,812,699.00
210101	Үндсэн цалин	497,870,705.00	478,140,215.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	75,672,484.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,229,322.12	65,865,280.26
210201	Тэтгэврийн даатгал	36,605,562.16	47,315,208.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,959,461.27	3,663,663.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,924,523.90	4,141,839.05
210204	Ажилгүйдлийн даатгал	931,252.25	647,434.18
210205	Эрүүл мэндийн даатгал	9,808,522.54	10,097,135.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,793,279.77	91,800,000.00
210304	Байрны түрээс	119,793,279.77	91,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,486,055.25	55,198,474.00
210401	Бичиг хэрэг	16,319,180.00	19,513,380.67
210402	Тээвэр, шатахуун	7,237,000.00	6,917,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,090,595.25	8,591,583.33
210404	Ном, хэвлэл	00.00	18,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	839,280.00	2,176,410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	1,550,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	140,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	1,410,350.00
2107	Томилолт, зочны зардал	6,265,807.00	26,100,980.00
210701	Гадаад албан томилолт	00.00	2,620,000.00
210702	Дотоод албан томилолт	6,265,807.00	23,480,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273,309,700.00	160,476,390.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,347,180.00	21,755,990.86
210803	Даатгалын үйлчилгээ	2,386,920.00	2,475,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,500.00	197,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,321,200.00	1,161,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	181,078,900.00	134,886,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,024,201,017.27	1,287,195,728.91

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	979,945,489.00	975,481,074.87
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,255,528.27	311,714,654.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,746,571.02	81,191,177.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,546,571.02	81,191,177.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	105,385,061.73	53,924,483.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	191,370,215.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	191,370,215.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-191,370,215.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	105,385,061.73	-137,445,732.23

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,165,453,427.16	2,111,265,867.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	861,737,394.16	865,060,497.87
120	Нийтлэг татварын бус орлого	861,737,394.16	865,060,497.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	861,737,394.16	848,709,497.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,711,319.16	848,709,497.87
120009	Бусад орлого	00.00	16,351,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,303,716,033.00	1,246,205,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,125,976,700.00	1,130,113,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,125,976,700.00	1,130,113,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,849,500.00	116,092,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	116,092,270.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,011,645,427.16	2,003,340,867.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,011,645,427.16	2,003,340,867.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,993,898,856.14	1,922,149,690.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,299,756.93	553,812,699.00
210101	Үндсэн цалин	234,847,944.93	351,899,945.66
210102	Нэмэгдэл	47,404,700.00	106,422,369.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,817,900.00	18,817,900.00
210104	Урамшуулал	10,429,212.00	1,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,800,000.00	75,672,484.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,724,397.98	66,345,680.26
210201	Тэтгэврийн даатгал	35,724,397.98	65,285,680.26
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,060,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,793,279.77	91,800,000.00
210304	Байрны түрээс	119,793,279.77	91,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,894,555.25	56,494,533.33
210401	Бичиг хэрэг	16,540,180.00	20,809,440.00
210402	Тээвэр, шатахуун	7,237,000.00	6,917,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,090,595.25	8,591,583.33
210404	Ном, хэвлэл	00.00	18,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,026,780.00	2,176,410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	1,625,350.00

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	215,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	1,410,350.00
2107	Томилолт, зочны зардал	6,265,807.00	26,100,980.00
210701	Гадаад албан томилолт	00.00	2,620,000.00
210702	Дотоод албан томилолт	6,265,807.00	23,480,980.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	456,953,135.21	159,845,990.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	286,105,955.21	21,125,590.86
210803	Даатгалын үйлчилгээ	2,386,920.00	2,475,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,500.00	197,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,321,200.00	1,161,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	164,963,560.00	134,886,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,002,717,924.00	966,124,457.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	991,691,849.00	966,124,457.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,746,571.02	81,191,177.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,546,571.02	81,191,177.22
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,546,571.02	81,191,177.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>153,808,000.00</u>	<u>107,925,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	153,808,000.00	107,925,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	153,808,000.00	107,925,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	153,808,000.00	107,925,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	153,808,000.00	107,925,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-153,808,000.00</u>	<u>-107,925,000.00</u>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	936,360,846.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	936,360,846.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	105,385,061.73	105,385,061.73
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	696,748,710.36	1,041,745,907.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	73,802,676.24	73,802,676.24
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	770,551,386.60	1,115,548,584.03

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	137,445,732.23	-137,445,732.23
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	633,105,654.37	978,102,851.80

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,988,408,100.00	1,913,985,464.65	(74,422,635.35)	96.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,988,408,100.00	1,913,985,464.65	(74,422,635.35)	96.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,988,408,100.00	1,913,985,464.65	(74,422,635.35)	96.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,822,800.00	478,140,215.00	172,317,415.00	156.3
Үндсэн цалин	176,030,500.00	351,899,945.66	175,869,445.66	199.9
Нэмэгдэл	109,974,400.00	106,422,369.34	(3,552,030.66)	96.8
Унаа хоолны хөнгөлөлт	18,817,900.00	18,817,900.00	-	100.0
Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,698,800.00	57,416,207.26	20,717,407.26	156.5
Тэтгэврийн даатгал	24,465,800.00	56,356,207.26	31,890,407.26	230.3
Тэтгэмжийн даатгал	3,058,200.00	00.00	(3,058,200.00)	-
ҮОМШӨ-ний даатгал	2,446,600.00	00.00	(2,446,600.00)	-
Ажилгүйдлийн даатгал	611,700.00	00.00	(611,700.00)	-
Эрүүл мэндийн даатгал	6,116,500.00	1,060,000.00	(5,056,500.00)	17.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	31,588,600.00	31,195,933.33	(392,666.67)	98.8
Бичиг хэрэг	13,371,400.00	13,510,840.00	139,440.00	101.0
Тээвэр, шатахуун	6,917,100.00	6,917,100.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,570,400.00	8,591,583.33	(978,816.67)	89.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,729,700.00	2,176,410.00	446,710.00	125.8
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,625,350.00	(374,650.00)	81.3
Урсгал засвар	1,500,000.00	1,410,350.00	(89,650.00)	94.0
Томилолт, зочны зардал	36,116,000.00	26,100,980.00	(10,015,020.00)	72.3
Гадаад албан томилолт	3,000,000.00	2,620,000.00	(380,000.00)	87.3
Дотоод албан томилолт	33,116,000.00	23,480,980.00	(9,635,020.00)	70.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,923,800.00	159,845,990.86	(255,077,809.14)	38.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,824,600.00	21,125,590.86	(193,699,009.14)	9.8
Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,475,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	273,700.00	197,500.00	(76,200.00)	72.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,950,000.00	1,161,000.00	(1,789,000.00)	39.4
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	194,400,500.00	134,886,900.00	(59,513,600.00)	69.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,069,458,100.00	1,067,860,788.20	(1,597,311.80)	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,068,177,100.00	1,067,860,788.20	(316,311.80)	100.0

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,988,408,100.00	1,913,985,464.65	(74,422,635.35)	96.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,120,460,600.00	1,065,275,966.78	(55,184,633.22)	95.1
Улсын төсвөөс санхүүжих	1,120,460,600.00	1,065,275,966.78	(55,184,633.22)	95.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	867,947,500.00	848,709,497.87	(19,238,002.13)	97.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	844,947,500.00	848,709,497.87	3,761,997.87	100.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,000,000.00	00.00	(23,000,000.00)	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	36	12.00	150.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	23	35	12.00	152.2

5.1 АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:

2018
он

Аудитын
нэр:

Санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийх

Аудитын код:

САГ-2019/376/СТА-ТШЗ

Шалгагдсан

БСШУСЯамны дэргэдэх Боловсролын
үнэлгээний төв

мянган төгрөгөөр

А	1	2	3	4	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Зардал	1	Боловсролын үнэлгээний төвийн 14 гэрээт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 171,358.2 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 20,717.4 мянган, нийт 192,075.6 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ зардлаар тайлагнасан нь төлөвлөснөөс 56.3-56.5 хувиар буюу орон тоо 12 ажилтнаар хэтэрсэн байна.	171,075.6	Зөвлөмж өгсөн	2019.02.25		Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
2	Орлого	1	Арилжааны банкны харилцах дансаар 855,670.1 мянган төгрөгийн элсэлтийн шалгалтын хураамжийн орлого орсноос банкны шимтгэлийн хураамжийг хасч, 848,559.5 мянган төгрөг Төрийн сангийн харилцахад орсныг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.	7,110.6	Зөвлөмж өгсөн	2019.02.25		Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
3	Мөнгөн хөрөнгө	1	Жижиг мөнгөн сангаас 2018 онд Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-д нэр заагдаагүй бараа материал, цай кофе, бичиг хэрэг, цэвэрлэгээний материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, шуудан, холбоо, үйл ажиллагааны зардалд нийт 10,400.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Бэлэн мөнгөөр гүйцэтгэх бараа, ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг 18 гүйлгээгээр 5.666,7 мянган төгрөг хэтрүүлэн зарцуулсан байна. Төсөв захирагчийн гарын үсэг 2 янзаар зурагдсан кассын баримт дээр цохолт хийгдээгүй зөвхөн гарын үсгийн дардас дарагдсан байна	5,666.7	Зөвлөмж өгсөн	2019.02.25		Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
4	Эрх зүй	1	Тус төвийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, тэмдэг дээрх хуулийн этгээдийн нэр зөрүүтэй байна. Үүнд: Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хуулийн этгээдийн нэр /113874 дугаартай/ - "Боловсролын үнэлгээний төв", тэмдэг дээрх хуулийн этгээдийн нэр - "БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв" "ТБАГУТҮГ", Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хариуцлагын хэлбэр - "Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэж бичсэн нь хариуцлагын хэлбэр тодорхойгүй байна		Зөвлөмж өгсөн	2019.02.25		Захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр

